



**МОНГОЛ УЛСЫН
СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРОО**

15141 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Ж.Самбуугийн гудамж 11, Засгийн газрын XI байр,
Утас: 26 09 75, Факс: (976-11) 32 69 75,
E-mail: gecm@gec.gov.mn, http://www.gec.gov.mn

2020.05.15 № 2/155
танай _____-НЫ № _____-Т

УЛСЫН ИХ ХУРЛЫН 2020 ОНЫ
ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД
ОРОЛЦУУЛАХААР БҮРТГҮҮЛСЭН
НАМ, ЭВСЭЛД

**Нэр дэвшигчдийн баримт бичиг
хүлээн авах тухай**

Нэг. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2-т зааснаар нэр дэвшүүлсэн нам, эвсэл нь нэр дэвшүүлэх ажиллагааны талаарх хуульд заасан хугацаа дууссан өдрөөс хойш тав хоногт буюу 2020 оны 5 дугаар сарын 17-ны өдрөөс 21-ний өдрийг дуусталх хугацаанд дараах баримт бичгийг бүрэн бүрдүүлэн Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлнэ.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2.1-д зааснаар нэр дэвшүүлсэн тухай хуралдааны шийдвэр, нийт нэр дэвшигчийн нэрийн жагсаалтад дараах баримт бичгийг хавсралтаар хүргүүлсэн баримт дахь дарааллын дагуу нэр дэвшигч тус бүрээр бүрдүүлэн хавсаргаж ирүүлнэ. Үүнд:

- 1.нэр дэвшигч бүрийн бичгээр өгсөн зөвшөөрөл;
- 2.нэр дэвшигчийн намтар;
- 3.нэр дэвшигчийн иргэний үнэмлэхийн хуулбар;
- 4.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4-т заасан албан тушаалтан бол ажил, албан тушаалаас чөлөөлөгдсөн тухай шийдвэрийн хуулбар;
- 5.ял эдэлж байгаа эсэх талаарх цагдаагийн төв байгууллагын мэдээллийн сан хариуцсан нэгжийн лавлагаа;
- 6.авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож байсан эсэх талаарх цагдаагийн төв байгууллагын мэдээллийн сан хариуцсан нэгжийн лавлагаа;
- 7.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 29.3.1-д заасан нэр дэвшигчид тавигдах шаардлагыг хангасан эсэх талаарх Улсын Дээд шүүхийн лавлагаа;
- 8.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 29.3.2-т заасан нэр дэвшигчид тавигдах шаардлагыг хангасан эсэх талаарх татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын тодорхойлолт;
- 9.нэр дэвшигчийн хөрөнгө орлогын мэдүүлгийн баталгааны маягт.

000356

Хавсралтаар хүргүүлсэн баримтад нэр дэвшигчийн эцэг/эхийн нэр, өөрийн нэрийг тойргийн дэс дарааллын дагуу бичиж gesc@gesc.gov.mn хаягаар уг маягтыг урьдчилан ирүүлнэ.

Нэр дэвшүүлсэн шийдвэр болон нийт нэр дэвшигчдийн нэрийн жагсаалтыг нэр дэвшигч тус бүрээр бүрдүүлэх шаардлагагүй.

Хоёр: Улсын онцгой комиссын 2020 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 20 дугаар хуралдаанаас гаргасан “Сонгуулийн ерөнхий хороонд нэр дэвшигчийн баримт бичгийг хүлээн авах үйл ажиллагаанд дагаж мөрдөх зөвлөмж”-ийн дагуу баримт бичгийг хүлээн авах ажиллагааг дараах байдлаар зохион байгуулахаар тус Хорооноос шийдвэрлэсэн болно.

1. Нам, эвслээс нэр дэвшигчийн баримт бичгийг 2020 оны 5 дугаар сарын 17-ны өдрөөс 21-ний өдрүүдэд 10:00, 12:00, 14:00, 16:00 цагуудад хүлээн авна.

2. Баримт бичгийг хоёроос илүүгүй хүний төлөөлөл хүлээлгэн өгнө.

3. Баримт бичгийг хүлээлгэн өгөх төлөөлөл ирэхдээ амны хаалт /маск/, нэг удаагийн бээлийтэй байна.

4. Нам, эвслийн төлөөлөл Төрийн тусгай хамгаалалтын ажилтанд хувийн бичиг баримтаа шалгуулж, гараа ариутгасны дараа холбогдох баримт бичгээ ажлын хэсэгт хүлээлгэн өгнө.


Дээр дурдсан хуваарийн дагуу нам, эвслээс нэр дэвшигчдийн баримт бичгийг хүлээн авах ажиллагааг зохион байгуулах тул баримт бичгээ хүлээлгэн өгөх өдөр, цаг, хүлээлгэн өгөх хоёр хүний нэр, албан тушаал, холбогдох утасны дугаар, цахим шуудангийн хаяг зэрэг мэдээллийг gesc@gesc.gov.mn цахим хаягаар урьдчилан ирүүлнэ.

Уг асуудлаар тус Хорооны Захиргаа, санхүүгийн хэлтсийн ахлах шинжээч С.Баасанхүү /264896/, Хууль эрх зүйн хэлтсийн дарга Д.Бат-Эрдэнэ /262127/ дугаар утсаар холбогдож мэдээлэл авах боломжтой.

“Монгол Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуульд ... нам /эвсэл/-аас нэр дэвшигчдийн баримт бичгийг Сонгуулийн ерөнхий хороонд хүлээн авсан тухай баримт”-ын маягтыг хавсаргав.

Хүндэтгэсэн,

НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА



Ц.БОЛДСАЙХАН

Монгол Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуульд

**нам /эвсэл/-аас нэр дэвшигчдийн баримт бичгийг
Сонгуулийн ерөнхий хороонд хүлээн авсан тухай баримт**

№	Тойргийн дугаар	Нэр дэвшигчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр	Нэр дэвшүүлсэн тухай хуралдааны шийдвэр	Нийт нэр дэвшигчийн нэрийн жагсаалт	Бичгээр өгсөн зөвшөөрөл	Нэр дэвшигчийн иргэний үнэмлэхийн хуулбар	Нэр дэвшигчийн намтар	Ажил, албан тушаалаас чөлөөлөгдсөн тухай шийдвэрийн хуулбар	Ял эдэлж байгаа эсэх талаарх цагдаагийн төв байгууллагын лавлагаа	Авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн гэм буруутгайд тооцож байсан эсэх талаарх Цагдаагийн төв байгууллагын лавлагаа	Улсын Дээд шүүхийн лавлагаа	Татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын тодорхойлолт	Хөрөнгө орлогын мэдүүлгийн баталгааны маягт	Тайлбар
			3	4	5	6	7	8	9	10	11	12	13	
A	1	2												
1														
2														
3														
...														

Нийт хуудас баримт бичиг хүлээн авав.

- Жич:** 1/ 1, 2 дугаар баганыг тойргийн дугаарын дарааллын дагуу бөглөх;
2/ 3, 4 дүгээр багана дахь баримт бичгийг 1 хувь ирүүлэх /нэр дэвшигч тус бүрт бүрдүүлэх шаардлагагүй/;
3/ Дээрх хүснэгт дэх баримтын дарааллын дагуу нэр дэвшигч тус бүрээр баримт бичгийг бүрдүүлэн багцалсан байна.

ХҮЛЭЭЛГЭН ӨГСӨН:

.....
нам /эвсэл/-ын.....
.....ажилтан
.....
/гарын үсэг/
.....
/гарын үсгийн тайлал/
.....
нам /эвсэл/-ын.....
.....ажилтан
.....
/гарын үсэг/
.....
/гарын үсгийн тайлал/

ХҮЛЭЭН АВСАН:

Сонгуулийн ерөнхий хорооны АА-ны.....
.....
/гарын үсэг/
.....
/гарын үсгийн тайлал/
Сонгуулийн ерөнхий хорооны АА-ны.....
.....
/гарын үсэг/
.....
/гарын үсгийн тайлал/

2020 оны 5 дугаар сарын-ны өдрийн цаг минут



УЛСЫН ОНЦГОЙ КОМИСС

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Партизаны гудамж 6, Утас: 26 21 26,
Факс: (976-51) 26 35 54, И-мэйл: uok@nema.gov.mn

2020.05.05 № 754


танай _____-ны № _____-т

СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ ДАРГА Ч.СОДНОМЦЭРЭН ТАНАА

Улсын онцгой комиссын 2020 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 20 дугаар хуралдаанаас Монгол Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгууль зохион байгуулах үед КОВИД-19 халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг Улсын онцгой комиссын зөвлөмж болгон Сонгуулийн ерөнхий хороонд хүргүүлэх шийдвэр гарсаны дагуу Монгол Улсын Сонгуулийн тухай хуульд заасан нам, эвслээс нэр дэвшүүлэх, бие даан нэр дэвшүүлэх үйл ажиллагаа мөн түүнчлэн Сонгуулийн ерөнхий хороонд нэр дэвшигчийн баримт бичиг хүлээн авах үйл ажиллагаанд дагаж мөрдөх зөвлөмжийг боловсруулан хүргүүлж байна.

Хавсралт 4. хуудастай.

ДАРГА,
ШАДАР САЙД





Ө.ЭНХТҮВШИН



Гурав. Сонгуулийн ерөнхий хороонд нэр дэвшигчийн баримт бичиг хүлээн авах үйл ажиллагаанд:



3.1. Хүн бүр амны хаалт зүүсэн байна.



3.2. Хүн бүр бээлий өмссөн байна.

3.3. Баримт бичиг хүлээн авагчийг гараа угаах боломжоор хангана.

3.4. Баримт бичиг хүлээн авагч нь амны хаалт зүүн, бээлий өмсөж баримт бичгийг хүлээн авна.



3.5. Баримт бичиг хүлээн авах өрөөг сайтар цэвэрлэн, 30 минут тутамд цэвэр агаар оруулна.